

ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Зорилт ын дугаар	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдах зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Нийт хөрөнгийн эх үүсвэр /сая.төг/	Нийт хөрөнгийн хэмжээ /сая/	Шалгуур үзүүлэлт	2025		Төсөв	Арга хэмжээний биелэлт	ӨӨРИЙН ҮНЭЛТЭЭ
							Суурь түвшин	Хүрэх түвшин үр дүнгийн үзүүлэлт			
ЭРҮҮЛ МЭНД											
		2.3.1.1.1. Өвчлөлийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах	2025-2028	УТ, ОНТ	87	Өвчлөлийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамрагдсан иргэдийн хамрагдалтын хувь	40	42	15	Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалт 10 сарын байдлаар 70836 буюу 49.3%-тай байна. Нийт хамрагдсан иргэдийн 71.2%-д нь өвчлөл илэрсэн бөгөөд 18-с дээш насны иргэдэд хоол боловсруулах замын эмгэг тэр дундаа ходоодны улайлт, үрэвсэл, шархлаа, элэгний вирусны халдвар, элэгний өөхжилт зэрэг өвчин зонхилон тохиолдож байна. Нийт үзлэгт хамрагдсан иргэдийн 31-с дээш насны дурантай багцад 29160 иргэн хамрагдсан бөгөөд ходоодны хавдрын 23 тохиолдол илэрсэн.	100
		2.3.1.1.2. "Эрүүл шүд" хөтөлбөрийн хүрээнд орон нутагт хүүхдийн шүдний тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар хүүхдийн шүдний өвчлөлийг бууруулах	2025-2028	УТ, ОНТ	7.5	Шүдний эмчилгээнд хамрагдсан хувь	38	44		"Эрүүл шүд" арга хэмжээний хүрээнд 18 сургууль, 45 цэцэрлэг хэрэгжүүлэн шүд угаах цагийг бий болгон хэвшүүлэн ажиллаж байна. 2025 онд багш ажилчдын санаачилгаар Хэрлэн 5, Хан Хэнтий, Тэмүүжин сургуулиуд шүд угаах орчныг сайжруулж тохижуулалт хийсэн. "24/3 шүдээ зөв угаая" аяны хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн 48 бүлгийн 2480 суралцагчдад "Амны хөндийн эрүүл мэнд" сэдвийн хүрээнд сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж цахим хуудсаар дамжуулан 25680 иргэд олон нийтэд мэдээ мэдээлэл хүргэн ажилласан. Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суралцаж буй суралцагчдын амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор амны хөндийн анхан шатны үзлэгийг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч, сургуулийн эмч, нийгмийн ажилтан нар хамтран зохион байгуулсан. Үзлэгт хамрагдвал зохих 2-18 насны 26804 хүүхэд байгаагаас хамрагдалт 10888 /40,6%/, үүнээс 6630 хүүхдэд өвчлөл илэрсэн буюу 60.8% нь шүдний өвчлөлтэй байна.	90

24	2.3.1.1 Эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжих чиглэлээр иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, зонхилон тохиолдох өвчлөлөөс сэргийлнэ.	2.3.1.1.3. Зорилтот бүлгийн хүн амд халдварт ба халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар эрүүл мэндийн боловсрол олгох, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах	2025-2028	ОНТ, Төсөл хөтөлбөр	35	Сургалт сурталчилгаанд хамруулсан зорилтот бүлгийн иргэдийн хамрагдалтын хувь	60	65	5	Хэнтий аймгийн хэмжээнд эхний 10 сарын байдлаар "Осол гэмтлээс сэргийлэх 0-5 насны хүүхдийн аюулгүй орчин" сарын аян, Хорт хавдрын эсрэг анхаарал хандуулах сарын аян, Дархлаажуулалтын 10 хоног, Дэлхийн тамхигүй өдөр, 24/3 шүдээ зөв угаа сарын аян, Тамхигүй ирээдүй сарын аян, Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аян зэрэг нийтдээ 7 чиглэлийн арга хэмжээний хүрээнд 11 сэдвээр Эрүүл мэндийн газраас иргэдэд 53, Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас 195 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулан зорилтот бүлгийн 64.2%-г буюу 18-с дээш насны 4565 иргэд олон нийт, өсвөр насны 3640 хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсролыг хүргэн ажилласан. Мөн цахим хуудсаар дамжуулан дунджаар 17360 иргэд олон нийтэд мэдээ мэдээлэл хүргэсэн. Эрүүл шүд арга хэмжээний хүрээнд өсвөр насны 560 гаруй хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн сэдвээр сурган зохион байгуулсан. Улаанбурхан өвчний дэгдэлттэй холбоотой нөхөн дархлаажуулалтыг эрчимжүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 16 ЕБС, 27 цэцэрлэгийн хүүхдүүдийн 1505 эцэг, эх асран хамгаалагч нарт дархлаажуулалтын ач холбогдолын талаар сургалтыг зохион байгуулж улаанбурхан өвчний нөхөн дархлаажуулалтын хамралтын 17% -р нэмэгдүүлж 80%-д хүрсэн.	90
		2.3.1.1.4."Эрүүл монгол хүн" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах	2025-2028	ОНТ	4	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь		90		"Эрүүл монгол хүн" үндэсний хөтөлбөрийн 7 чиглэлийн арга хэмжээний хүрээнд нийт 253 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулан зорилтот бүлгийн 17585 иргэд олон нийтийг хамруулан эрүүл мэндийн боловсролыг хүргэн ажилласан. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 90.2% байна.	100
		2.3.1.1.5.Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-т өвчнийг тандах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийн эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлэх	2025-2028	УТ, ОНТ, төсөл хөтөлбөр	60	эмчилгээний хамрагдалтын хувь	Сүрьеэгийн эмчилгээний хамрагдалт 85, БЗДХ эмчилгээний 80%	Сүрьеэгийн эмчилгээний хамрагдалт 87, БЗДХ эмчилгээний 82%	15	Хэнтий аймгийн Сүрьеэ, БЗДХ-ын тусламж үйлчилгээ 2025 оны 10 дугаар сарын байдлаар Баян-Адарга, Батширээт, Дадал, Норовлин, Бэрх, Өмнөдэлгэр сумд болон Хэрлэн сумын бүх багийн нийт 792 иргэн идэвхтэй илрүүлэгт хамрагдаж, нийт шинээр илэрсэн сүрьеэгийн 52, БЗДХ-ын 58 тохиолдол тус тус бүртгэгдэснийг хяналтад авч эмчилгээнд хамруулсан. Зорилтот бүлгийн иргэдийн 82%-ийг илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулан ажилласан. БЗДХалдварын эмчилгээний хамрагдалт 82.3%, сүрьеэгийн эмчилгээний хамрагдалт 87.4% байна.	100
		2.3.1.1.6.Хавдрын эсрэг арга хэмжээ	2025-2028	УТХО, ОНТ, төсөл хөтөлбөр	260	Хавдрын эрт үеийн оношилгооны хамрагдалтын хувь	48	50	80	Арга хэмжээний хүрээнд хойд болон зүүн бүсийн сумдын эрсдэлт бүлгийн нийт 1223 иргэдийг эрт илрүүлэг, үзлэг, оношилгоонд хамруулж шинээр хавдрын 8 /элэг-3, ходоод-2, умайн хүзүү-1, хөх-1, уруул-1/ тохиолдолыг оношилж хяналтад авсан. Мөн Улсын 2-р төв эмнэлгийн хавдарын эмч нартай хамтран зонхилон тохиолдож буй хавдрыг эрт илрүүлэх үзлэг оношилгоог зохион байгуулж, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхижуулан ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулан ажилласан. Аймгийн хэмжээнд хавдрын хяналтад 963 хүн байгаагаас 2025 оны 11 сарын байдлаар 178 шинэ тохиолдол бүртгэгдснийг 48.7% нь эрт үедээ оношлогдсон. Цаашид орон нутагт хавдрын хими эмчилгээг нутагшуулах зорилгоор үндэсний баг болон ХСҮТ-тэй хамтран хавдрын хими эмчилгээний эмч-1, сувилагч-1, 2-эм зүйч нарын сургаж бэлтгээд байна.	95

25	2.3.2.1 Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжиж, сэргийлж болох хүүхдийн эндэгдлийг бууруулна.	2.3.1.2.1."Сэргийлж болох эндэгдлийг бууруулах нь" арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028	УТ, ОНТ, төсөл хөтөлбөр, бусад	80	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл промилль	15.1	14.6	20	Орон нутгийн хэмжээнд нярайн чиглэлээр сэргийлж болох эндэгдлийн бууруулж ажиллах зорилгоор 2025 оны 05 сард орон нутгийн санхүүжилтээр нярайн амьсгалын аппарат, неонап, ургийн монитор, Дезрит ОУ-ын байгууллагаас биллимитр, отоскопия, нярайн шарлагын аппарат, дулаацуулах ширээгээр хангагдаж дутуу төрөлт, нярайн эндэгдлийг өмнөх оны мөн үеэс 8 тохиолдлоор бууруулж ажилласан. Хүүхдэд зонхилон тохиолдох эмгэгүүд, амьсгалын замын эмгэг сэдэвт сургалтыг АШУУИС-ийн багш нартай хамтран нийт 65 эмч, мэргэжилтэнийг ажлын байрны чадавхжуулах сургалтад хамрагдуулж суулгалтаар хүүхдийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй ажиллаж байна. Мөн ЭМЯ-аас хүүхдэд тохиолдох томуу болон томуу төст өвчний эмнэлзүйн заавар сэдэвт сургалтад 22 байгууллагын 127 эмч, мэргэжилтэн цахимгаар хамрагдаж амьсгалын замын шалтгаант хүүхдийн эндэгдлийг бууруулсан. Салбар дундын оролцоотой зам тээврийн осол, усанд живэх, галд өртөх зэрэг осол гэмтлээс сэргийлэх шторк, мэдээллийг вебсайт, орон нутгийн мэдээллийн хэрэгслээр давхардсан тоогоор 4154 иргэдэд хүргэснээр осол гэмтлийн шалтгаант хүүхдийн эндэгдлийн тохиолдол өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор буурсан. Эхний 10 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 12 тохиолдол бүртгэгдсэн ба 1000 амьд төрөлтөд 14.6 промилль	100
		2.3.1.2.2. "Төрөх насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, дутуу төрөлтөөс сэргийлэх" арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028	ОНТ, Төсөл хөтөлбөр	65	Нярайн эндэгдэл промилль	13.9	12.9	20	"Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжиж, сэргийлж болох хүүхдийн эндэгдлийг бууруулах" арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Хэрэгжилтийн хүрээнд "Төрөх насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, дутуу төрөлтөөс сэргийлэх" сэргийлж болох эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлс сэдвүүдийн хүрээнд бүсчилсэн сургалтыг урд, зүүн, хойд бүсийн сумдад зохион байгуулсан. Тус сургалтаар өсвөр насны - 281 охид, нөхөн үржихүйн насны-668, жирэмсэн-154, хөхүүл ээж-196 нийт-1299 эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгосон. Сургалтын дараа нийт-12 нярай, 99 жирэмсэн ээжийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдуулж зөвлөгөө өгч ажилласан. Сургалтын өмнө оролцогчдыг судалгаа бөглүүлж эрүүл мэндийн мэдлэгийг үнэлэв. Сургалтад оролцогчдын сэтгэл ханамж 100% үнэлэгдсэн. Сэргийлж болох осол гэмтлийн шалтгаант хүүхдийн эндэгдэл өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор буурсан. Эхний 10 сарын байдлаар нярайн эндэгдлийн 3 тохиолдол бүртгэгдсэн ба 1000 амьд төрөлтөд 3.3 промилль байгаа нь өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор буюу 9.2 промилиор буурсан үзүүлэлттэй байна.	100
		2.3.1.3.1. Эрүүл аж төрөх арга зүйд иргэд, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургах мэдээллийн нээлттэй танхим ажиллуулах	2025-2028	ОНТ	17.5	Сургалтад хамрагдсан хүний тоогоор	1100	2200		Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлэх зорилгоор УАУНЭ-ийн сургалтын танхимыг түшиглэн 4 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 2227 иргэнийг хамруулсан байна.	100

26	2.3.1.3 Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлнэ.	2.3.1.3.2."Элэгний архаг үрэвсэл", "ЧШХШ-2" зэрэг халдварт бус өвчлөлийг УАУ-ны бие хэл, сэтгэл засал хосолсон бүрэн цогц тусгай хөтөлбөрт эмчилгээг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шинэлэгч бүтээгдэхүүн болгон хэрэгжүүлэх	2025-2028	ОНТ, бусад	16.5	Эмчилгээнд хамрагдсан хүний тоо өссөн дүнгээр	40	80		Элэг цөсний өвчин, Чихрийн шижин хэвшинж –II үеийн уламжлалт анагаах ухаанаар хүндрэлээс урьдчилан сэргийлэх үеийн тусгай эмчилгээний хөтөлбөр боловсруулан нийт 56 эмчлүүлэгчийг эмчилгээнд хамруулж элэг цөс, чихрийн шижин өвчний үеийн хоол эмчилгээний тусгай цэс боловсруулж эмчлүүлэгч нартаа өгөн, биеийг хоргүйжүүлэх, хордлого тайлах, дархлаа дэмжих, хүндрэлээс урьдчилан, цус шингэлэх, муу цус тамирын цусыг ялгах хануур засал эмчилгээг хийсэн. Эмчилгээний үр дүнд захын цусан дахь глюкозын хэмжээ 5,0 ммоль хүртэл бууж биеийн байдал сайжирсан үзүүлэлттэй буюу хөтөлбөрт эмчилгээний үр дүн 96% байна.	100
27	2.3.1.4 Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх	2.3.1.4.1.Бичил биетний эсрэг эмийн зарцуулалтыг хянах мэдээллийн санг үүсгэж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх	2025-2028	ОНТ, төсөл хөтөлбөр	20	Мэдээллийн сан үүсгэсэн ЭМБ-уудын тоо	0	30	5	Эмийн чанар, аюулгүй байдал, бүртгэл, цахим хяналтын тогтолцоог бий болгох зорилгоор Бичил биетний тэсвэржилтийн илрүүлэлт, тандалтыг сайжруулж бичил биетний тэсвэржилтийн мэдээллийг цахимд шилжүүлж эхэлсэн. Одоогоор АНЭ, Ачманал, Хэрлэндом, Оюуны шим ЭЭМТ-үүд, Мөрөн, Жаргалтхаан, Тахилгат, Цэнхэрмандал СЭМТ-үүд бичил биетний эсрэг эмийн мэдээллийн сан үүсгэж, зарцуулалтыг хянаж эхэлсэн буюу эрүүл мэндийн байгууллагуудын 32,1% мэдээллийн сан үүсгэсэн. Нийт хэрэглэсэн бичил биетний эсрэг эмийн 85% нь тарилгын хэлбэр болохыг тооцоолсон. Антибиотик мэдрэг чанар тодорхойлсон-941, үүнээс пенициллины бүлэгт 53%, цефалоспорины бүлэгт-25% тэсвэржилт үүссэнийг тогтоосон.	100
28	2.3.1.5 Цахим эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангаж дэвшилтэт технологи телемедицинийг өргөжүүлэх	2.3.1.5.1. Цахим мэдээллийн аюулгүй байдлын системийг нэмэгдүүлэх	2025-2028	УТХО, ОНТ, төсөл хөтөлбөр	285	ЭМБ-ын тоо	1			2025 онд Цахим эрүүл мэндийн яамнаас 1 удаа, ЭМГаараас 5 удаа эрүүл мэндийн байгууллагуудад сургалт зохион байгуулсан. 1-4-р улиралд ЭМГаараас эрүүл мэндийн салбарын цахим мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар харьяа мэдээлэл технологийн инженер, эрүүл мэндийн салбарын статистикч эмч нар цахимаар сургалт зохион байгуулж сургалтанд нийт давхардсан тоогоор 89 хүн хамрагдсан. ЭМБ-ууд эмч мэргэжилтнүүд цахим мэдээллийн аюулгүй байдлын сургалтад 2 удаа хамрагдсан ба нийт 4 ЭМБ-д зөвшөөрөлтэй вирусны программуудыг нийт 48 эмч мэргэжилтний компьютерт суулган, цахим мэдээллийн аюулгүй байдлын журмыг 2 байгууллага шинэчлэн боловсруулж мөрдөн ажиллаж байна.	100
		2.3.1.5.2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран авах боломжийг нэмэгдүүлж, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологийг сайжруулах	2025-2028	УТХО, ОНТ, төсөл хөтөлбөр	60	Телемедицинэ эр дамжуулан үзүүлэх тусламж үйлчилгээг нэмэгдүүлсэн ЭМБ-ын тоо	1			Аймгийн нэгдсэн эмнэлэг нь эх барих яаралтай тусламжийн чиглэлээр 32, гэмтлийн чиглэлээр 19, мэдрэлийн чиглэлээр 9, төрөх, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чиглэлээр 26 удаа тус тус телемедиценээр зөвлөгөө, тусламж үйлчилгээ авсан. 2025 онд Бор-Өндөр ХНЭ-т телемедицинээр лавлагаа шатлалын эмнэлгүүдээс тусламж үйлчилгээг авах боломжийг бүрдүүлсэн.	100

		2.3.1.5.3. Алслагдсан бүс нутагт оршин суугаа хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэх зорилгоор Мобайл технологийг нэмэгдүүлэх	2025-2028	УТХО, ОНТ, төсөл хөтөлбөр	120	Нэмэгдсэн ЭМБ-ын тоо	1	1		ЭМСайдын тушаалын дагуу Баянхутаг, Батноров, Баянмөнх, Галшар, Өлзийт сумуудад мобайл технологийг нэвтрүүлсэн ба нийт 12 байгууллага мобайл технологиор хангагдаж иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж ажиллаж байна.	50
29	2.3.1.6 Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх	2.3.1.6.1.Эмч эмнэлгийн мэргэжилтнийг өндөр хөгжилтэй оронд туршлага чадавхижуулах	2025-2028	УТХО, ОНТ, төсөл хөтөлбөр	110	Туршлага судалсан эмч эмнэлгийн ажилтны тоо	15	5	20	Эмнэлгийн мэргэжилтний мэдлэг ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд анхаарч БНСУ-ын Намъянжу хотод байрлах Эль (EL) эмнэлэг, Жолла мужийн Чон-Жу хотод байрлах Хью Саранг, ОХУ-ын Эрхүү хот, Өвөрбайгалийн тарваган тахал эсэргүүцэх станц болон эмнэлэгтэй харилцан хөгжих зорилгоор 7 чиглэлд хамтын ажиллагаа, солилцооны гэрээг байгуулж ажилласан бөгөөд гэрээний дагуу ЭМГ-2, АНЭ-8, Анхан шатны ЭМБ-3, УАУНЭ-1, ЗӨСТ-5 эмч, эмнэлгийн мэргэжилтэн 7-21 хоногийн сургалтад тус тус хамрагдсан байна. Цаашид гэрээний дагуу эрүүл мэндийн байгууллагын дарга, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг үе шаттайгаар богино хугацааны сургалтад хамруулах, туршлага судлуулах ажлыг зохион байгуулж байна. Төрийн санхүүжилтээр гадаадад суралцагчтай байгуулах гэрээний дагуу сумын эрүүл мэндийн төвийн 1 их эмч, УАУНЭ-ын 1 их эмч БНХАУ-ын ӨМӨЗО-ны Олон Улсын Монгол эмнэлгийн хороонд 3 сарын сургалтад хамрагдсан.	100
		2.3.1.6.2.Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд эмч эмнэлгийн ажилтнуудыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах	2025-2029	ОНТ, төсөл хөтөлбөр	210	Арга хэмжээнд хамрагдсан эмч ажилтнуудын тоо		8	60	ЭМС-ийн эмч эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд орон нутгаас нийт 60 сая төгрөгийг АНЭ-ийн болон Бор-Өндөр ХНЭ-ийн 4 гэр бүлийн 7 эмч мэргэжилтэнд орон сууцны урьдчилгааг, ЗӨСТ, Баянхутаг сумын ЭМТ, Хэрлэнбаян Улаан тосгоны ЭМТ, Хэрлэндом ЭЭМТ, АНЭ зэрэг 5 байгууллагын сувилагч тусгай мэргэжилтнийг 5 ханатай гэрээр хангасан. 20 сум тосгоны 23 их эмч, 9 сувилагч, 1 бага эмч эмчийн байранд амьдарч байна. 2025 онд Мөрөн, Галшар, Биндэр, Норовлин сумын ЭМТ шинээр ажилд орсон 3 их эмч, 2 сувилагч тусгай мэргэжилтнийг эмчийн байраар хангасан. Биндэр сумын ЭМТ шинээр ажилд орсон 1 эмч, 1 сувилагчийг 50 толгой бог малаар малжуулсан.	100
30	2.3.1.7 Эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж, барилга, автомашины хангалтыг нэмэгдүүлнэ.	2.3.1.7.1. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн стандартын хангалтыг 8 хувиар нэмэгдүүлнэ.	2025-2028	УТХО, ОНТ, төсөл хөтөлбөр	320	Стандарт хангалтын хувь	55	57	800	2025 онд Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн "Сургуульд суурилсан хүүхдийн эрүүл мэндийн эрт илрүүлгийн үндэсний тогтолцоог бий болгох" заалтын хүрээнд ЭМЯамнаас орон нутагт 87.477.500 сая төгрөгийн санхүүжилтээр 25 ширхэг ECG S120 ухаалаг зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар хангасан. Мөн ЭМЯамны хөрөнгө оруулалтаар Бор-Өндөр ХНЭ-т 431.9 сая төгрөгийн уян дурангийн иж бүрдэл, 83.1 сая төгрөгийн суурин ЭХО аппарат, орон нутгийн хөрөнгө оруулалтаар АНЭ-т нярайн амьсгалын аппаратыг тус тус олгосон.	70
		2.3.1.7.2.Авто машин нэн шаардлагатай Эрүүл мэндийн байгууллагыг авто машинаар хангах	2025-2028	УТХО, ОНТ, төсөл хөтөлбөр	700	Автомашинаар хангагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо	30	2	100	Ачманал ӨЭМТ, Биндэр, Батширээт ЭМТөвүүдэд түргэн тусламжийн автомашин олгосон. Галшар, Баянхутаг, Батширээт, Өлзийт, Дэлгэрхаан СЭМТөвүүд түргэн тусламжийн автомашины засвар үйлчилгээнд 15.8 сая төгрөгийг тус тус зарцуулан ажилласан.	100

		2.3.1.7.3. ЭМБ-уудын барилгын өргөтгөл, урсгал болон их засвар хийх	2025-2028	УТХО, ОНТ, төсөл хөтөлбөр	9.801.5	Өргөтгөл засварс хийгдсэн барилгын тоо	4	4	4.701.5	2025 онд шинээр ашиглалтад орсон эмнэлгийн барилга байгууламж байхгүй болно. Цэнхэрмандал СЭМТөвийн өргөтгөл, Хэрлэн сумын жишиг өрхийн эмнэлэг /Хэрлэн дом/-ийн шинэ барилга Бэрх сумын эрүүл мэндийн төвийн их засварын ажлуудын санхүүжилтүүдийг 100% шийдвэрлэн ажилласан.	100
			Үнэлгээний дундаж								93.7

ТАЙЛАН БИЧСЭН:ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНМИЧИД

ХЯНАСАН: ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ДАШНАМЖИЛМАА